

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2023/03

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.III	2022.III	2023.II	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2022 оны эцэст	их наяд ₮, оны үнээр	-	-	52.8	-	1.1%▲	-	4.8%▲
Инфляц	хувь	12.2%	14.4%	12.2%	0%▼	-	3.4%▲	-2.2 нэгж хувиар▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	-	-	5.3% 2022.IV	-	0.1%▼	-	-2.8%▼
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	656.6	-257.7	22.6	-	-	-	914.3▲
Ам.долларын ханш	төгрөг	3524.98	2901.83	3508.06	16.92▲	-	-	623.15▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	1824.37	251.4	1045.32	-	-	-	1527.97▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	14.1	2.5	8	-23.75%▼	-	-	564%▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	362.9	334.832	218.5	-33.9%▼	-	-	108%▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	6%	13%	0%	-	0%	7%▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.44	3.32	3.39	1.5%▲	-	-	3.6%▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	9.58%	9.62%	9.93%	-0.35%▼	-	-	-0.04%▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

<ul style="list-style-type: none"> Экспорт өмнөх оны мөн үеэс 96.0 хувиар өслөө 	2023 оны 3 дугаар сард монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.7 тэрбум америк долларт хүрч, нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 (57.9%) тэрбум америк доллароор, экспорт 1.8 (96.0%) тэрбум америк доллароор, импорт 248.9 (14.7%) сая америк доллароор тус тус өсжээ.
<ul style="list-style-type: none"> Улсын нэгдсэн төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 29.6 хувиар өсжээ 	Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 5.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (29.6%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 4.8 их наяд төгрөг болж, 1.2 (34.4 %) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:

Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
1. Мөнгөний бодлогын хүүг 13%-д хэвээр хадгалах шийдвэр гарлаа	2023/03/15	БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогын арга хэмжээ суларч, эрчим хүч болон худалдааны салбараас бусад салбарын идэвхжил хүлээлтээс өндөр гарсан нь нөлөөллөө.
2. Улаанбаатараас орон нутагт шилжсэн хүмүүст орон сууцны 3%-ийн хүүтэй зээл олгож эхэлжээ.	2023/03/23	Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжин суурьшсан иргэн, ААН-ийг Засгийн газраас бодлогоор дэмжих

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Инфляц



Нөлөөлөл

Инфляц 2023 оны 3 дугаар сард өмнөх сараас 1.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.8 хувь, зочид бүүдал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 4.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Валютын ханш



Америк долларын ханш 2023 оны 3 дугаар сард 3524.98 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 623.15 төгрөгөөр, өмнөх сараас 16.92 төгрөгөөр суларсан байна. Монгол банкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2023 оны 3 дугаар сард 511.39 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.14 төгрөгөөр суларч, өмнөх сараас 2.41 төгрөгөөр чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 1.5%-иар өсч, 3.44 тэрбум ам.долларт хүрээд байна.

Улсын төсөв


(тэрбум төгрөг)



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 5.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (29.6%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 4.8 их наяд төгрөг болж, 1.2 (34.4 %) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 оны эхний улиралд 4.1 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 656.6 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа

(тэрбум америк доллар)



Гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 3.8 тэрбум америк доллар, импорт 1.9 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 (57.9%) тэрбум америк доллароор, экспорт 1.8 (96.0%) тэрбум америк доллароор, импорт 248.9 (14.7%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2023 оны 3 дугаар сард экспорт өмнөх сараас 354.7 (30.4%) сая америк доллароор, импорт 231.3 (45.3%) сая америк доллароор тус тус өссөн байна.

Дэлхийн эдийн засагт

- АНУ-ЫН ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ 0.25 НЭГЖ ХУВИАР ӨСГӨЛӨӨ
Эх сурвалж: ВВС
- АВСТРАЛИД ХУВИАРАА ХАЙГУУЛ ХИЙДЭГ ИРГЭН АСАР ТОМ АЛТНЫ ХҮДЭР ОЛЖЭЭ
Эх сурвалж: ВВС

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 3-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо](#)

2. [Статистикийн бюллетень, 3-р сар 2023 он, Монголбанк](#)

3. www.1212.mn, www.mongolbank.mn